

## БҮЛЭГ1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр:

Увс аймгийн Наранбулаг сумын нутагт орших “Харганат” төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

### 1.2 Төслийн зорилго:

Харганат төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн зорилго нь төмрийн хүдрийг олборлон эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

### 1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

“Эй Эл Жи Ти” ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын 9019022116 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Ашигт Малтмалын Газраас “Эй Эл Жи Ти” ХХК-нд 2008 оны 06 сарын 02-ны өдрийн шийдвэрээр Увс аймгийн Наранбулаг сумын нутагт орших MV-013766 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Харганат” нэртэй төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон байна.

Төсөл хэрэгжүүлэгч	“Эй эл жи ти” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019022116
Регистрийн дугаар	5130662
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-013766
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо энхтайвны өргөн чөлөө 13/3 Авзага трейп ХХК-ийн байр 804 тоот
Утас	99994774

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

### 1.4 Төслийн хүчин чадал:

Ил уурхайн ашиглалтын хугацаанд 43.5 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулж овоолгод байршуулахаар байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг захиалагч компанийн техникийн даалгаврын дагуу эхний 10-н жилд 250.0 мян.тн, 11-31 жилд 500.0 мян.тн хүчин чадалтайгаар 31 жил ашиглахаар төлөвлөлөө.

### 1.5 Уулын ажлын горим

Уулын ажил нь жилд 9 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 1 ээлжээр 10 цагаар явагдана.

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	270
Жилд ажиллах сар	сар	9
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	1
Ээлжинд ажиллах цаг	цаг	10
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	2
<b>Жилд ажиллах хугацаа</b>	<b>хоног</b>	<b>250</b>

### 1.6 Үйлдвэрлэлийн нөөц

Харганатын ордын хүдрийн ордын нөөцийн тодотгол тооцоог 2017 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн В+С зэргээр нийт 15.02 сая.тн төмрийн хүдрийн нөөцийг бүртгүүлсэн.

### 1.7 Уурхайн ашиглалтын систем

Ордын уул-техникийн нөхцөл, хүдрийн биетийн геологийн тогтцыг харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

#### 1.7.1 Уурхайн ашиглалтын элементүүд

**Доголын өндөр:** Хүдрийн хаягдал бохирдлыг бага байлгах, хүдрийн биетийн цул тогтцоос хамааруулан уурхайн ажлын доголын өндрийг Нд=5м байхаар тооцов. Доголын өндөр бага байснаар хүдэр хөрсний чулуулгийн зааг орчимд үүсэх хаягдал болон бохирдлын хэмжээ багасах нөхцөл бүрдэнэ.

**Ажлын бус доголын өндөр:** Уурхайн ажлын доголыг цаашид ашиглахгүй, ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголын өндөр 10м байна.

**Ажлын доголын хажуугийн налуугийн өнцөг:** Ажлын доголын хажуугийн налуугийн өнцгийг чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр тодорхойлоход хөрс, хүдрийн доголд  $\alpha_d=60^0$  байна.

**Ажлын талбайн өргөн:** Ажлын талбайн өргөнийг төсөлд дараах 2 хувилбараар тусгалаа.

- a) Хамгийн бага ажлын талбайн өргөн (Налуу траншейгаар нээх үед)
- b) Хэвийн ажлын талбайн өргөн

Шинээр ашиглалтын түвшин нээхэд огтлох траншейгаар нээнэ. Траншей

нээх, ажиллах техникийн аюулгүй зайн нөхцөлөөр ажлын талбай тодорхойлогдоно. Ажлын хамгийн бага өргөн 25 м-ээс багагүй байна.




График 1 Нөөц хуваарилалт

## 1.8 Уурхайн дэд бүтэц

### 1.8.1 Уурхайн барилга, байгууламж

Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн баруунд талд байрлана.

Хүснэгт 2 Барилга байгууламж хийц бүтэц

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Оффис	Сэндвич	1
2	Амралтын байр	Сэндвич	1
3	Гал тогоо	Сэндвич	1
4	Сэлбэг, материалын агуулах	Сэндвич	1
5	Авто гараж	Сэндвич	1
6	Үйлдвэрийн байр	Сэндвич	1
7	Харуул хамгаалалтын байр	Сэндвич	2
8	Түлшний агуулах	Ёмкость	3
	<b>Дүн</b>		<b>11</b>

Түлш хадгалах зориулалтаар 60 тоннын 3 сав бүхий түлшний агуулах, масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

### **1.8.2 Машин техник, тоног төхөөрөмжийн завсар үйлчилгээ**

Уурхайд иж бүрэн засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт токарийн суурь машин, дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

Уурхайн механик тоног төхөөрөмж, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн агрегатын их засвар, томоохон хэмжээний урсгал засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх засвар зэрэг ажлыг тухайн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж нийлүүлсэн компанийн засварын газар болон техникийн зохих түвшинд тоноглогдсон, дагнасан засварын газар, байгууллагад гүйцэтгүүлэхээр төсөлд авч үзэв.

### **1.8.3 Цахилгаан хангамж**

Одоогийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан хангамжаа 30 дизл цахилгаан үүсгүүрээр хангаж байна.



Зураг 1 Уурхайн хотхоны дизл станц



Зураг 2 Уурхайн талбайн дизл станц

Уурхайн нийт цахилгааны хэрэглээг ашиглалтын 3 дахь жилээс Увс аймгийн Наранбулаг сумын төвөөс 10 кВт-ын ЦДАШ татаж хангахаар төлөвлөсөн. Уурхайд ил уурхайн гэрэлтүүлэг, баяжуулах үйлдвэр, засварын цех, хотхоны хэрэглээ гэсэн цахилгаан хэрэглэгч байна.

#### **1.8.4 Усан хангамж**

Орд газрын орчимд урсгал ус байхгүй. Хүдрийн биетүүд дээр өрөмдөгдсөн 80м хүртэл гүнтэй цооногуудад усны давхарга илрээгүй, хөндий хоолойд өрөмдөгдсөн худгуудын усны түвшин нь хүдрийн биетүүдийн түшингээс хэдэн арав, зуун метрийн доор байрлалтай байдаг. Ордын гидрогеологийн нөхцөл байдал нь хуурай, хөрсний болон гүний усны ямар нэгэн илрэл ажиглагдаагүй учир гидрогеологийн ямар нэгэн хүндрэл байхгүй.

## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

### 2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил


Ашигт Малтмалын Газраас “Эй Эл Жи Ти” ХХК-нд 2008 оны 06 сарын 02-ны өдрийн шийдвэрээр Увс аймгийн Наранбулаг сумын нутагт орших MV-013766 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Харганат” нэртэй төмрийн хүдрийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон байна.

Сумын Засаг даргын захирамж 2021 оны 06 сарын 18 өдрийн А/120 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 8511000592 дугаар бүхий 112 га газрыг Уурхайн газрын зориулалтаар эзэмшүүлж гэрчилгээ олгосон.

Сумын Засаг даргын захирамж 2021 оны 04 сарын 22 өдрийн А/59 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 8511000629 дугаар бүхий 17 га газрыг үйлдвэрийн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлж гэрчилгээ олгосон.

Хүснэгт 3 MV-013766

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	92° 11' 39.19"	49° 36' 51.79"
2	92° 10' 39.19"	49° 36' 51.79"
3	92° 10' 39.19"	49° 37' 21.78"
4	92° 11' 39.19"	49° 37' 21.78"



Зураг 3 Талбайн нисгэгчгүй нисдэг төхөөрөмжөөр зурагласан зураг

## 2.2 Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл

Увс аймгийн баруун өмнө хэсэгт:

- Улаанбаатар хотоос 1268 км,
- Аймгийнхаа төвөөс 90 км зайд байрладаг.

Увс аймгийн Завхан, Өлгий, Өмнөговь, Наранбулаг, Малчин сумуудтай хиллэдэг

**Газарзүй:** Далайн түвшнээс дээш 1200-1800 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Хан хөхийн нурууны үргэлжлэл Тогтохын шилийг дамнан Увс, Хяргас нуурын дунд оршдог.

Газар хөдлөлийн эрчим: 7 балл. Сумын нутаг дэвсгэрийн 20% нь хангай, 50% нь говь, 30% нь тал хээрийн бүс эзэлдэг. Газар Наранбулаг, мал аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой.


Увс аймаг нь Монгол орны баруун хойморт Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69.6 мян.км. ёа газар нутагтай. Баруун талаараа 200 км Баян-Өлгий, өмнө талаараа 152 км Ховд аймаг, зүүн талаараа 340 км Завхан аймаг, хойд талаараа 575 км ОХУ-тай тус тус хиллэдэг.

Нийслэл Улаанбаатараас 1400 орчим км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог. Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас, мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой. Нутаг дэвсгэрийн 8.2%-ийг уулын ойт хээр, 14.5%-ийг өндөр уулын, 37.7%-ийг хээрийн, 39.6%-ийг говь цөлийн бүс эзэлдэг.

Байгалийн мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Ийнхүү мөнх цаст өндөр уулсын бүслүүрээс ойт хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран орших нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг нэгэн зэрэг хөгжүүлэх давуу талтай.

Хамгийн нам цэг нь д.т.д 758.9 метрт буй Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь д.т.д 4250 метрт өргөгдсөн Цагаан Дэглий оргил юм. Хархираа, Түргэний салбар уулс д.т.д 4000 метрээс дээш өндөртэй 31 цаст оргилуудтай.

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ




Зураг 4 Байгалийн бүс бүслүүр



### 2.3 Төслийн талбайн газрын гадаргын налуужилт:


Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газрын барилга, байгууламж барьжбайгуулахад ихээхэн нөлөөтэй болохыг зураг төсөл боловсруулах, барилга байгууламжбарих талбайн бэлтгэл, газар шорооны ажилтай шууд холбож үздэг. Газрын гадаргынналуу ихсэх тутам газар шорооны ажлын хэмжээ мөн төдий чинээ нэмэгддэгтэйхолбоотой.Иймд газрын гадаргын налуугийн олон төрөл байдал нь хот төлөвлөлтийн үүднээсээзлэхүүн, орон зайн төлөвлөлтөд өвөрмөц үүрэг гүйцэтгэх нь маргаангүй бөгөөд хот,суурингийн янз бүрийн үүрэг зориулалтын бүсүүдийг гадаргын налуугийн хүчин зүйл,тухайн суурингийн онцлог байдалтай уялдуулан төлөвлөж барьж байгуулах нь зүйтэй юм.



Зураг 5 Газрын гадаргын налуужилт

## 2.4 Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын өндөршилт:

Хот, суурингийн байрлаж буй газрын өндөржилт ихсэх тутам агаарынхүчилтөрөгчийн агуулга болон темпратур буурч, өдөр шөнийн температурын зөрүү огцомөсч, салхины хүч ширүүсэн, агаарын хуурайшил нэмэгдэн, цаг уурын бусадөөрчлөлтүүдээс шалтгаалж, оршин суугчдын ая тухтай байдал алдагдан, эрүүл мэндэднөлөөлөхөөс гадна барилга байгууламжийн ашиглалтад сөрөг үр дүн үзүүлдэг байна.Эмнэлэг-биологийн шаардлагаас үндэслэн, хот байгуулалтын хувьд далайнтүвшнээс дээш 1500 м хүртэл өндөржилттэй бол тохиромжтой, 1500-2500м хүртэл хязгаарлагдмал тохиромжтой, 2500 м-ээс дээш тохиромж муутай нөхцөлд үнэлэгдэж байна.




Зураг 6 Газрын гадаргын өндөршилт

### БҮЛЭГ 3. УУР АМЬСГАЛ

Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм.

Өвлийн улиралд агаарын даралт 1-р сард 1054 гПа болж, агаарын температур 1-р сард Зүүнговь, Тэс, Улаангом зэрэг ихэнхи сумдад -50 С буй хүрдэг нь монгол оронд тэмдэглэгдсэн хамгийн бага утга тул Увс нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг.

Хархираагийн салбар уулс нь шовх оройтой огцом хэрчигдэлтэй гуу жалга элбэгтэй 2100-2500 м-ийн үнэмлэхүй өндөртэй. Нуурын хотгорын баруун талын намхавтар уулс нь 1700-2000 м үнэмлэхүй өндөртэй, хэрчигдэлд хүчтэй орсон гуу жалга элбэгтэй мөлгөрдүү оройтой. Талбайн хамгийн өндөр цэг нь Харлаг хар уул 2542 м, хамгийн нам цэг нь Бургастайн голын хөндийн адгийн өндөр дэнж 1632 м юм. Талбай нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай богино зунтай, урт өвөлтэй, хамгийн хүйтэн нь 1-р сард -20° -35°, хамгийн халуун нь 7-р сард +18° - (+25°) байх ба жилдээ 100-180 мм хур тунадас унана.Ю-р сарын дунд үеэс 5-р сарын эх хүртэл цасан бүрхүүл тогтоно. 11-р сарын эхээр газар хөлдөж эхлэх бөгөөд хөрсний хөлдөлтийн гүн нь 3 м хүрнэ.



Month	Temp	Precip
Jan	-29.4	7.2
Feb	-25.3	6.8
Mar	-13.3	9.1
Apr	2.2	21.3
May	10.7	22.8
Jun	16.9	33.5
Jul	18.9	55.0
Aug	16.7	49.3
Sep	10.3	25.1
Oct	1.6	18.4
Nov	-12.1	16.9
Dec	-24.2	11.5

График 2 Уур амьсгал

Хүснэгтэд үзүүлснээр агаарын температур, хур тунадасны дундаж хэмжээ 7 дугаар сард 18.9°C 55.5мм их , 1-р сард -29.4°C 7.2 мм бага үзүүлэлттэй байна

### 3.1 Агаарын температур:

Төслийн районд жилийн дундаж температур -30,9-19,6 °C байна. Хамгийн их хүйтрэлт 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог.

Увс аймгийн нутаг дэвсгэр нь хотгор гүдгэрийн ялгаа ихтэй байдаг учраас өвөл зуны температурын ялгаа их байдаг. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1-р сар бөгөөд хүйтний улирлын жилийн дундаж температур нь Тэс, Баруунтуруун, Улаангом, Малчин, Зүүнговь, Түргэн, Давст сумын нутгаар 31,0-35,1 градус , Хар-ус, Завхан, Өндөрхангай сумын нутгаар 22,1-28,3 градус хүйтэн байна. Жилийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь нийт сумын нутгаар 18.4-26.2 градус дулаан байна. Судалгааны материалаас үзэхэд: Агаарын дундаж температур 2005 онд Тэс суманд -37,40с, Улаангом, Баруунтуруун суманд -34,9-35,20с хүрч тус тус хүйтэрч байсан байна.




График 3 Агаарын температур

### 3.2 Хур тунадас

Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтын тооцооны үр дүнг харвал нам өргөрөгийн нутгаар буюу говь цөлийн бүсэд жилдээ арав хүрэхгүй см хур тунадас орох бөгөөд заримдаа энд хэдэн жил ч бороо орохгүй тохиолдол бий. Энэ нь агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээ бага байдагтай шууд холбоотой юм. Оронзайн тархацын хувьд Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 150-50 мм орчим хур тунадас унана. Монгол орны газарзүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг байна. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой бадаг. Жишээлбэл, 7 сард хойд өргөргийн 42 градусын бүслүүр дээр 31 мм, өргөргийн 46 градусын бүслүүр дээр 52 мм, өргөргийн 50 градусын бүслүүр дээр 96 мм хур тунадас тус ордог байна. Энэ зүй тогтол жилийн хамгийн хүйтэн 1-р сард мөн жилийн нийлбэр үед ч гэсэн хадгалагдаж байна. Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /VI-IX сард/ үүнээс зөвхөн 7, 8 дугаар сард 30.3мм 36,4мм нь орно.



График 4 Хур тунадас

### 3.3 Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцлөөс ихээхэн шалтгаалдаг. 0 50 100 150 200 250 300 1935 1945 1955 1965 1975 1985 1995 2005 2015 Тунадас, мм Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь тайлан 2014он Газрын мэргэжлийн байгууллага “Газар дэлхий”ХХК 32 Монгол орны тал хээр, говь, цөлийн бүс нь салхи ихтэй байдаг. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгийн уулс хоорондын хөндийд 1-2 м/с, бусад нутгаар 2-3м/с орчим байдаг. Тус орны 250 хот суурин орчимд хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр нутгийн дөрөвний нэг орчимд нь жилийн дундаж салхины хурд 4.0 м/с-ээс их. Ихэнхдээ баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч газрын хотгор гүдгэрийн нөлөөгөөр орон нутгийн ялангуяа уулхөндийн салхи элбэг тохиолдоно. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтаа тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.




График 5 Салхины дундаж хурд

Увс аймгийн нутгаар салхины сарын дундаж хурд 0,3-3,3 м/с-ийн хооронхэлбэлзэх ба дунджаар 2 орчим м/с, салхины хамгийн их хурд 28-40 м/с хүрдэг бол 15 м/сээс их салхитай өдөр дунджаар 12 өдөр тохиолддог байна.

Улаангом станцад 3 ба 4-р сард салхины хамгийн их хурд 40 м/с хүрдэг бол хүчтэй салхитай өдрийн тоо харьцангуй цөөн буюу 4 хоног ажиглагддаг байна.

Салхины дундаж хурд сумын хувьд 1.3 м/с-2.2 м/с байна. Салхины сарын дундаж хурд альч сард 4-өөс хэтрэхгүй. Салхины хамгийн их хурд ихэнх сумдад 20 м/с буюу түүнээс доош байна. Салхи намуун байх давтагдал өвлийн улиралд хамгийн их Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь тайлан 2014он Газрын мэргэжлийн байгууллага байдаг нь энэ бүс нутагт хүйтэн улиралд эсрэг циклон тогтвортой байрладагтай холбоотой.

### **3.4 Салхины чиглэл:**

Салхины чиглэл нь тухайн газар орны хотгор гүдгэрийн онцлогоор голчлон тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл уулархаг орон нутагт жилийн хүйтэн улиралд хүйтэн агаар өндөрлөг газраасаа нам газар луугаа чиглэн урсах хүндийн хүчний салхи зонхилох ба жилийн дулаан улиралд шатлуур багатай нам даралтын оронд салхины чиглэл тогтворгүй болох хандлага ажиглагдана. Увс аймгийн нутагт газрын хотгор гүдгэрийн онцлогоос болоод уулын хавцал дагуу баруун, зүүний салхи ажиглагдана. Салхины чиглэлийн тухайд өмнөдийн салхины давтагдал жилийн турш бусад чиглэлийн давтагдлаас давуу байдаг онцлогтой.

#### **БҮЛЭГ 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Увс аймгийн Наранбулаг сумын нутагт Харганат төмрийн ордыг ил уурхайн аргааж ашиглах төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах,



УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Хүснэгт № 1 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

БОМТ-ний нийт зардал	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө	1.0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1.5
Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	1.0
Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.0
Удирдлага зрхион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	1.0
Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0.5
Нийт	8.0 сая төгрөг

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 2 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
						2024 он	
Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: - Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Ү.а-ны турш		-	500.0	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа	БОС-ын 1995 оны153тоот тушаал
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах	Ү.а-ны турш		-	-	2024	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Ү.а-ны турш		-	ҮА-ны зардал	2024	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
<b>Хөрсөн бүрхэвч</b>							

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, авто зогсоолыг тэмдэгжүүлэх	Үйл ажиллагааны турш		-	Ү.а-ны зардлаар	2024	
	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Үйл ажиллагааны турш		-	Ү.а-ны зардлаар	2024	
	Уурхайн нойлыг стандартад нийцүүлэн соруулдаг технологи ашиглах	Үйл ажиллагааны турш		-	Ү.а-ны зардлаар	2024	MNS 5924:2015
<b>Усан орчин</b>							
Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Төслийн явцад		-	Ү.а-ны зардлаар	2024	
	Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	Галын аюулгүй ажиллагааны хүрээнд		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	2024	
	Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт	Ажилчдын байрны хүрээнд		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард 1 удаа	
Нийт зардал		1250.0 мян.төг					

**БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашиглалтын үйл ажиллагаа дуусаагүй тул нөхөн сэргээль хийгдэхгүй болно.

**БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2024	
<b>Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө</b>						
1	Аймаг орон нутгаас өгсөн санал	Сумын нутаг дэвсгэрт хамаарах бөхөнгийн тархац бүс нутгуудад /Биотехникийн/ арга хэмжээ авах, давс хужир, өвс тэжээл, бэлтгэх	Ү.а-ны эхэнд	2024 он	ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	
2	Өвөлжөө хүндэрч байгаа тул айлуудад тусламж үзүүлэх				ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013
3	Шар бүрд нуурийн эхийг хамгаалах					
3	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	0.6 га талбайд 600 ширхэг мод тарих	0.6 га талбайд			
4	Аймаг орон нутгаас өгсөн санал	Наранбулаг сумын төвд хийгдэж байгаа цөлжилтөөс хамгаалсан ойн зурвасын хашааны 2 км газарт хашаажуулах ажлыг, тарьц суулгацын ажил хийгдэхээс өмнө бэлэн болгож				
4		0.5 га тал				
<b>Нийт дүн мян.төг</b>						<b>850.000</b>

### **БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

### **БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Эй эл жи ти” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол цехийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

**БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 4 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024 онд	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрцэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	-	100.0	200.0	2024 онд	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	-	-				
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	-	-				
Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	-	1	220.0		2024 онд	
<b>Нийт зардал (мян.төг)</b>				<b>670.0</b>			

### БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт № 5 Орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2024 он	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Хөрсний бохирдол</b>							
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Жил тутамд	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 1жил /15.0/ НИЙТ 60,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -15.0 төг	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс.
Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Жил тутамд	Жилд 1 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 20.0 төг/	
<b>Усны хяналт шинжилгээ</b>							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2024 он	Жилд 1 удаа	40.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2024 он				

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

							MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны зардлын дүн						300.0	



**БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардалм ян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2024 он	
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Үйл ажиллагааны турш	-	-	-		+	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заатлууд  Хог хаягдлын тухай хуулийн 14-рзүйл
	Аюултай хог хаягдлын дугаар авах	Үйл ажиллагааны турш					+	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	-	-	200.0	+	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих	Үйл ажиллагааны турш	-	-	-	300.0	+	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг тусгай бодис хэрэглэн задлах	Үйл ажиллагааны турш	-	-	-	100.0	+	
Аймгийн санал	Хог хаягдлын гэрээг Наранбулаг сумтай хийсэн бол тухайн сумын хогийн цэгт үүссэн хогийг тээвэрлэж хүргэх, ачилтын бүртгэлтэй болгох	Үйл ажиллагааны турш					+	
	Уурхайн орчинд хуурайшилттай үед тоосжилт үүсэхээс сэргийлсэн усалгааг тогтмол хийж усалгаа хийсэн бүртгэл, ашигласан усыг	Үйл ажиллагааны турш					+	

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	бүртгэлжүүлэх							
	Хог хаягдлын тээвэрлэлт, хог хаягдал зайлуулах, ажлыг бүртгэлтэй болгох	Үйл ажиллагааны турш					+	
	Орчныхоо эзэмшил газрын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Үйл ажиллагааны турш					+	
Нийт		950.0 мян.төг						

**БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 7 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2024 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2024 он
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Осол эрсдэлийн менежментийн зардалд		2024 он
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 12 сард
4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх				
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2024 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2024 он
7	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй	Уурхайн хэмжээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2024  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх			
8	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Улирал бүр
9	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Жил бүр
10	Байгаль орчны аудитын тайлан хилгэх	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Жил бүр
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал			620.000	

**БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт № 8 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлэгээр санал авах	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Увс аймгийн Наранбулаг сумын иргэдэд танилцуулж хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Увс аймгийн Наранбулаг сумын Засаг захиргааны байранд
	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт		Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	
Нийт зардал				-	